



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 05

Сүхбаатар сум

Г 2025 оны 3 дугаар улиралд хийсэн санхүүгийн
хяналт шалгалт, дотоод аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан Орхонтуул, Сайхан, Түшиг,Цагааннуур сумдын ТТЗ-ийн 2024,2025 оны 2 дугаар улирлын үйл ажиллагаанд дотоод аудит, Орхонтуул,Сайхан,Цагааннуур,Түшиг сумдын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Ерөө сумын Бугант тосгон, Ерөө бүсийн сум дундын ой анги, Сүхбаатар сумын Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн 2024, 2025 оны 2 дугаар улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хийсэн санхүүгийн хяналт шалгалт, шилэн дансны 3 улирлын дотоод аудитаар илэрсэн зөрчлийн дүн, дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг ханган ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсүгэй.

Санхүүгийн хяналт шалгалт,дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Орон нутгийн өмчит ААТҮГ-ын захирал, төсвийн байгууллагын дарга нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга:

Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Т.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд:




Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод
аудитын газрын дарга)



Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын
Тамгын газрын дарга)



Б.Энхтуяа
(Санхүү төрийн сангийн хэлтсийн
дарга)



Б.Янжинлхам
(Хууль эрх, зүйн хэлтсийн дарга)



А.Дашбат
(Иргэний төлөөлөл)



А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 20-ны
өдрийн 5 дугаар тогтоолын хавсралт



ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

МОНГО 9055053

(мян.төг)

д/д	Байгууллагын нэр	Илэрсэн зөрчлийн дүн	Эрсдэлийн үнэлгээ
1	Орхонтуул сумын Засаг дарга	723,568.1	"Сайжруулах шаардлагатай"
2	Сайхан сумын Засаг дарга	860,153.4	"Сайжруулах шаардлагатай"
3	Түшиг сумын Засаг дарга	1,548,028.1	"Сайжруулах шаардлагатай"
4	Цагаан нуур Засаг дарга	82,404.2	"Сайжруулах шаардлагатай"
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт		
6	Бэлчир бүсийн сум дундын ойн анги	30,900.0	"Бага" эрсдэлтэй
7	Ерөө сумын Бугант тосгоны захирагчийн алба	36,744.2	"Дунд" эрсдэлтэй
8	Ерөө бүсийн сум дундын ойн анги	89,229.1	"Дунд" эрсдэлтэй
9	Орхонтуул сумын Засаг даргын Тамгын газар	180,705.3	"Дунд" эрсдэлтэй
10	Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	4,209.2	"Дунд" эрсдэлтэй
11	Орхонтуул сумын рашаант тосгоны Захирагч алба	7,572.4	"Дунд" эрсдэлтэй
12	Сайхан сумын Засаг даргын Тамгын газар	128,348.4	"Дунд" эрсдэлтэй
13	Сайхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал		"Бага" эрсдэлтэй
14	Сайхан сумын Номгон тосгоны Захирагчийн алба		"Бага" эрсдэлтэй
15	Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар	174,558.7	"Дунд" эрсдэлтэй
16	Цагааннуур сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал		"Бага" эрсдэлтэй
17	Түшиг сумын Засаг даргын Тамгын газар	476,482.7	"Дунд" эрсдэлтэй
18	Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	41,718.1	"Дунд" эрсдэлтэй
19	Сант ХХС		
20	Мандал Энерго ОНӨААТҮГ		
	Дүн		

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ИРЦИЙН БҮРТГЭЛ

Д/д	Хорооны гишүүдийн нэрс	Албан тушаал	Гарын үсэг
1	Н.Лхагвадорж	Сэлэнгэ аймгийн Засаг дарга	
2	Т.Одсүрэн	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга	
3	Ө.Сувдаа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	
4	Б.Энхтуяа	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга	
5	Б.Янжинлхам	Хууль эрх, зүйн хэлтсийн дарга	
6	А.Гэрэлмаа	Иргэний төлөөлөл /Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын менежер/	
7	А.Дашбат	Иргэний төлөөлөл /Монголын Мэргэшсэн нягтлан бодогч/	